

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3.Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХСҮХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/511
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Оюуны өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Оюуны өмчийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлээр 80.0 хувийн биелэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,777,758.81</u>	<u>132,881,077.04</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,851,280.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,851,280.00
3121	Төгрөг	-	2,851,280.00
31211	Төрийн сангийн харилцах	-	2,851,280.00
34	УРЬДЧИЛГАА	-	73,989,073.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	73,989,073.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,777,758.81	56,040,724.04
351	Түүхий эд материал	10,885,350.00	9,713,500.00
35110	Тусгай зориулалттай материал	10,885,350.00	9,713,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	22,039,649.00
354	Хангамжийн материал	13,892,408.81	24,287,575.04
35410	Бичиг хэргийн материал	1,416,700.00	2,202,663.00
35420	Аж ахуйн материал	10,832,908.81	17,748,675.04
35440	Түлш, шатах тослох материал	1,360,000.00	3,523,000.00
35470	Бусад хангамжийн материал	282,800.00	813,237.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>501,501,091.77</u>	<u>544,846,806.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	501,501,091.77	544,846,806.12
392	Биет хөрөнгө	395,429,550.07	460,624,639.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,700,000.00	172,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,404,166.70)	(40,774,166.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,047,593,017.91	912,674,942.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(853,080,757.29)	(684,006,248.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,014,057.83	189,815,155.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(83,392,601.68)	(89,785,042.71)
393	Биет бус хөрөнгө	106,071,541.70	84,222,166.70
39301	Программ хангамж	297,923,964.00	297,923,964.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(191,852,422.30)	(213,701,797.30)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>526,278,850.58</u>	<u>677,727,883.16</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>526,278,850.58</u>	<u>677,727,883.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	526,278,850.58	677,727,883.16
512	Хуримтлагдсан үр дүн	526,278,850.58	677,727,883.16
51210	Өмнөх үеийн үр дүн	526,278,850.58	526,278,850.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	151,449,032.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>526,278,850.58</u>	<u>677,727,883.16</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,593,010,003.18	1,733,767,162.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	855,198,000.00	1,131,007,669.00
120	Нийтлэг татварын бус орлого	855,198,000.00	1,131,007,669.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	855,148,500.00	1,126,556,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	855,000,000.00	1,126,556,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148,500.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		1,599,989.00
120009	Бусад орлого	49,500.00	2,851,280.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	737,812,003.18	602,759,493.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,000,000.00	180,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,000,000.00	180,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	557,812,003.18	422,759,493.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	9,686,780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	557,812,003.18	413,072,713.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,280,734,614.40	1,577,722,770.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,280,734,614.40	1,577,722,770.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,551,757.84	1,378,875,725.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,637,497.36	568,483,946.47
210101	Үндсэн цалин	311,889,200.00	334,143,299.13
210102	Нэмэгдэл	31,744,893.00	155,101,199.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,003,404.36	53,139,447.36
210105	Гэрээт ажлын хөлс	-	26,100,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,504,870.75	67,736,841.87
210201	Тэтгэврийн даатгал	37,572,732.08	56,788,299.87
210202	Тэтгэмжийн даатгал	5,055,744.16	1,796,455.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,323,957.36	639,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	809,639.83	520,687.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,742,797.32	7,992,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,717,400.00	98,505,800.00
210304	Байрны түрээс	98,717,400.00	98,505,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,019,410.69	57,641,826.49
210401	Бичиг хэрэг	9,663,900.00	9,164,037.00
210402	Тээвэр, шатахуун	8,184,820.00	5,337,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,642,504.81	18,333,545.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,060.00	5,474,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,497,125.88	18,804,793.77
210408	Бараа материал акталсны зардал	-	528,150.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,160,850.00	18,572,349.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,563,800.00	14,867,949.00
210604	Урсгал засвар	597,050.00	3,704,400.00
2107	Томилолт, зочны зардал	37,580,611.00	21,626,162.00
210701	Гадаад албан томилолт	24,517,527.00	13,500,000.00
210702	Дотоод албан томилолт	13,063,084.00	8,126,162.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,016,249.15	413,389,374.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,289,687.15	355,823,480.00
210803	Даатгалын үйлчилгээ	385,560.00	2,850,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,601.00	167,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,718,001.00	43,498,294.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,478,400.00	11,027,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,914,868.89	132,919,425.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,015,607.00	12,540,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,899,261.89	120,379,425.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	219,182,856.56	198,847,044.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,550,000.00	131,260,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	131,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	144,550,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,632,856.56	67,587,044.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,162,587.18	27,635,903.94
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,470,269.38	39,951,140.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,000,000.00	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	65,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	312,275,388.78	156,044,392.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,595,360.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,595,360.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,595,360.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	312,275,388.78	151,449,032.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,729,946,903.18</u>	<u>1,732,181,973.70</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,506,300.00	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,506,300.00	-
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,506,300.00	-
118011	Бусад татвар (төлбөр, хураамж)	7,506,300.00	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	984,628,600.00	1,129,422,480.00
120	Нийтлэг татварын бус орлого	984,628,600.00	1,129,422,480.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	984,628,600.00	1,126,571,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	984,430,600.00	1,126,571,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	198,000.00	-
120009	Бусад орлого	-	2,851,280.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	737,812,003.18	602,759,493.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,000,000.00	180,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,000,000.00	180,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	557,812,003.18	422,759,493.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	9,686,780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	557,812,003.18	413,072,713.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,360,079,883.18</u>	<u>1,561,010,193.70</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,360,079,883.18	1,561,010,193.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,003,960,126.62	1,362,163,149.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,775,625.66	568,322,246.47
210101	Үндсэн цалин	311,889,200.00	333,981,599.13
210102	Нэмэгдэл	34,094,525.66	155,101,199.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,791,900.00	53,139,447.36
210105	Гэрээт ажлын хөлс	-	26,100,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,490,500.00	67,736,841.87
210201	Тэтгэврийн даатгал	37,224,476.37	56,788,299.87
210202	Тэтгэмжийн даатгал	3,034,423.63	1,796,455.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,261,700.00	639,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	815,400.00	520,687.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,154,500.00	7,992,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,717,400.00	98,505,800.00
210304	Байрны түрээс	98,717,400.00	98,505,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,216,524.81	57,535,945.72

210401	Бичиг хэрэг	10,000,000.00	10,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,544,820.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,642,504.81	18,333,545.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,060.00	5,474,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,998,140.00	16,228,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,917,660.00	102,469,473.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,320,610.00	24,776,000.00
210604	Урсгал засвар	597,050.00	77,693,473.00
2107	Томилолт, зочны зардал	37,580,611.00	21,626,162.00
210701	Гадаад албан томилолт	24,517,527.00	13,500,000.00
210702	Дотоод албан томилолт	13,063,084.00	8,126,162.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	297,246,198.15	433,426,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,833,537.15	361,031,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	385,560.00	2,850,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,601.00	167,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,540,000.00	58,795,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	14,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,342,500.00	10,545,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,015,607.00	12,540,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,015,607.00	12,540,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	356,119,756.56	198,847,044.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,550,000.00	131,260,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	131,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	144,550,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	139,063,456.56	67,587,044.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,470,269.38	27,635,903.94
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,162,587.18	39,951,140.70
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	129,430,600.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,506,300.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,506,300.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,000,000.00	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	65,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>369,867,020.00</u>	<u>171,171,780.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	369,867,020.00	168,320,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	369,867,020.00	168,320,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	369,867,020.00	168,320,500.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	369,867,020.00	168,320,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(369,867,020.00)</u>	<u>(168,320,500.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,851,280.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,851,280.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			214,003,461.80	214,003,461.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			214,003,461.80	214,003,461.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			00.00	00.00
Тайлант үеийн үр дүн			312,275,388.78	312,275,388.78
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			526,278,850.58	526,278,850.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			526,278,850.58	526,278,850.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			00.00	00.00
Тайлант үеийн үр дүн			151,449,032.58	151,449,032.58
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			677,727,883.16	677,727,883.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			00.0	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,306,556,400.00	1,278,920,496.06	27,635,903.94	97.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,306,556,400.00	1,278,920,496.06	27,635,903.94	97.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,303,456,400.00	1,277,660,496.06	25,795,903.94	98.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,401,800.00	568,322,246.47	1,079,553.53	99.81
Үндсэн цалин	333,981,600.00	333,981,599.13	0.87	100.00
Нэмэгдэл	155,101,200.00	155,101,199.98	0.02	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	54,219,000.00	53,139,447.36	1,079,552.64	98.01
Гэрээт ажлын хөлс	26,100,000.00	26,100,000.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,970,500.00	67,736,841.87	8,233,658.13	89.16
Тэтгэврийн даатгал	56,788,300.00	56,788,299.87	0.13	100.00
Тэтгэмжийн даатгал	4,795,800.00	1,796,455.00	2,999,345.00	37.46
ҮОМШӨ-ний даатгал	3,836,600.00	639,400.00	3,197,200.00	16.67
Ажилгүйдлийн даатгал	959,200.00	520,687.00	438,513.00	54.28
Эрүүл мэндийн даатгал	9,590,600.00	7,992,000.00	1,598,600.00	83.33
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,719,800.00	98,505,800.00	214,000.00	99.78
Байрны түрээс	98,719,800.00	98,505,800.00	214,000.00	99.78
Хангамж, бараа материалын зардал	58,872,700.00	58,307,845.72	564,854.28	99.04
Бичиг хэрэг	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,898,000.00	18,333,545.72	564,454.28	97.01
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,474,700.00	5,474,300.00	400.00	99.99
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,000,000.00	17,000,000.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	16,885,000.00	16,204,400.00	680,600.00	95.97
Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,500,000.00	-	100.00
Урсгал засвар	4,385,000.00	3,704,400.00	680,600.00	84.48
Томилолт, зочны зардал	27,220,000.00	21,626,162.00	5,593,838.00	79.45
Гадаад албан томилолт	13,500,000.00	13,500,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	13,720,000.00	8,126,162.00	5,593,838.00	59.23
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	449,086,600.00	441,457,200.00	7,629,400.00	98.30
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,076,600.00	369,076,600.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	2,850,400.00	2,850,400.00	-	100.00

Тээврийн хэрэгслийн татвар	190,600.00	167,300.00	23,300.00	87.78
Тээврийн хэрэгслийн оношлогоо	74,000.00	22,000.00	52,000.00	29.73
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,795,000.00	58,795,000.00	-	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,100,000.00	10,545,900.00	7,554,100.00	58.26
Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	5,500,000.00	1,800,000.00	75.34
Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	-	1,800,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	5,500,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,100,000.00	1,260,000.00	1,840,000.00	40.65
Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	1,260,000.00	1,840,000.00	40.65
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,100,000.00	1,260,000.00	1,840,000.00	40.65
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,306,556,400.00	1,278,920,496.06	27,635,903.94	97.88
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	180,000,000.00	152,364,096.06	27,635,903.94	84.65
Улсын төсвөөс санхүүжих	180,000,000.00	152,364,096.06	27,635,903.94	84.65
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,126,556,400.00	1,126,556,400.00	-	100.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,126,556,400.00	1,126,556,400.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
Төсвийн байгууллага	-	-	-	-
Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	31.00	31.00	-	-
Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00	-	-
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
Гэрээт ажилтан	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		422,759,493.70
УРСГАЛ ЗАРДАЛ		422,759,493.70
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		252,808,353.00
Эд хогшил, урсгал засварын зардал		238,444,073.00
Багаж, техник, хэрэгсэл		120,450,000.00
Тавилга		44,005,000.00
Урсгал засвар		73,989,073.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,324,280.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,324,280.00
Бараа үйлчилгээний бусад зардал		7,040,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,040,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		130,000,000.00
Бусад урсгал шилжүүлэг		130,000,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		130,000,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		39,951,140.70
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		39,951,140.70
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		422,759,493.70
Нэмэлт санхүүжилтийн орлого		422,759,493.70
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		9,686,780.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		413,072,713.70
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Оюуны өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйл ажиллагааны үндсэн орлогыг төрлөөр нь ангилан бүртгэх, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, холбогдох гүйлгээг бүртгэлд тусгах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын Хоёрдугаар газрын аудитын менежер Ц.Хосжаргал анхан шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Цэрэннамжил хариуцан гүйцэтгэв.

Оюуны өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Оюуны өмчийн газар нь 2020 онд 11 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөндөө тусгаж ажилласан бөгөөд 2020 оны онцлог ажлуудаас дурдвал:

- Оюуны өмчийн тухай хуулийг батлуулж, даган гарах Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль /Оюуны өмчийн багц хууль/-ийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.
- Оюуны өмчийн багц хуулийг даган гарах 1 тариф, 9 журмын төсөл боловсруулан иргэд байгууллагуудаас санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулж уг журмуудыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж ажилласан байна. /Оюуны өмчийн газрын үйлчилгээний хөлс", "Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн журам", "Аж үйлдвэрийн өмчийн эрхийн Маргаан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам", "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам", "Хамтын удирдлагын байгууллагуудын ажиллах журам", "Оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах журам", "Лицензийн гэрээ, оюуны өмчийн ашиглалттай холбоотой бусад гэрээг бүртгэх журам", "Оюуны өмчийн зуучлагчид тавигдах шаардлага, оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэх журам", "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн журам", "Оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журам"/
- Зохиогчийн эрхийн санд бүртгэлтэй 1994-2020 оны 12,284 ширхэг бүтээлийн жагсаалтыг оруулсан хайлт хийх боломжтой copyright.ipom.mn системийг ашиглалтад оруулсан байна. /Тус хайлтын систем ашиглалтад орсноор зохиогчийн эрхийн санд бүртгэлтэй 12,284 бүтээлийн зохиогч, эрх эзэмшигч, нэрээр цахимаар хайлт хийх бүрэн боломж бүрдсэн. Цаашид албан байгууллага, иргэд өөрийн биеэр ирэх болон албан бичиг ирүүлж лавлагаа авах шаардлагагүй бөгөөд цахимаар тухайн бүтээлийн мэдээллийг шуурхай авч болно. Мөн зохиогчийн эрхийн бүтээл

бүртгүүлэхээр ирүүлсэн мэдүүлгийн гэрчилгээ гарсан эсэхийг мэдэх боломжтой болсон./

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Оюуны өмчийн тухай хууль /2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулж 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/;
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр “Эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоол;
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар “Төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тогтоол зэрэг байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Оюуны өмчийн газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд Оюуны өмчийн газрын санхүүгийн үйл ажиллагаа болон шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,733,767.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 34,675.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Оюуны өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 151,449.0 мянган төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	0	2,851.3	2,851.3
Урьдчилгаа	0	73,989.1	73,989.1
Бараа материал	24,777.8	56,040.7	31,262.9

Үндсэн хөрөнгө	501,501.1	544,846.8	43,345.7
Нийт хөрөнгө	526,278.9	677,727.9	151,449.0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	526,278.9	677,727.9	151,449.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	526,278.9	677,727.9	151,449.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,851.3 мянган төгрөг болж 2,851.3 мянган төгрөгөөр өссөн нь Зөрчлийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1¹-д заасны дагуу хохирол нөхөн төлүүлсэн мөнгийг хохирогч талд өгөөгүй байгаагаас шалтгаалжээ. Энэ нь прокурорын хяналт доор 58 хоног шалгагдаж байгаад хохирогч талд өгдөг тул зайлшгүй байх үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,040.7 мянган төгрөг болж 31,262.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалтын 22,039.6 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэнтэй холбоотой байна.

Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас албан хаагчид цахимаар ажилласан тул компьютерт суулгах office программын лиценз болон вирусийн эсрэг программ суулгаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 544,846.8 мянган төгрөг болж 43,345.7 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар бэлтгэсэн 168,320.5 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс данснаас ТӨБЗГ-ын 2020 оны А-1/889 дугаар зөвшөөрөл олгох тухай албан бичгийн дагуу ХЗДХЯ-нд үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,923.6 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/890, А-1/1863 дугаар зөвшөөрөл олгох тухай албан бичгийн дагуу акталсан 245,513.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө буурсан нь тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардлаар хөрөнгийн үлдэх өртөг хасагдсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 677,727.9 мянган төгрөг болж 151,449.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Оюуны өмчийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 140,757.2 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого байна. Энэ нь Мадридын гэрээгээр Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас олгосон үйлчилгээний хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 296,988.1 мянган төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд байна. Энэ нь үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгө, шинэ байранд нүүж орсонтой холбоотой урсгал засварын зардал болон үйл ажиллагааны давсан орлогоос албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдсэнтэй холбоотой байна.

¹ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,323,349.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,323,349.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 16,793.3 мянган төгрөгөөр бууруулж 1,306,556.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,306,556.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 180,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,126,556.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 180,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 1,126,556.4 мянган төгрөг, нийт 1,306,556.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,278,920.5 мянган төгрөгийг зарцуулж 27,635.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,278,920.5 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь дотоод томилолтын зардлыг 5,593.3 мянга, улсын мэдээллийн маягт бэлдэх зардлыг 7,554.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8,233.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал 25,795.9 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал 1,840.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Дэлхийн оюуны өмчийн байгууллагын хамтын удирдлагын байгууллагуудад хуваарилсан орчуулгын 9,686.8 мянга, Мадридын болон ГАА-ын гэрээний дагуу орж ирсэн үйлчилгээний нэмэлт орлого 413,072.7 мянга, нийт 422,759.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 238,444.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 7,324.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 7,040.0 мянга, урсгал шилжүүлэгт 130,000.0 мянга, нийт 382,808.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 39,951.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 103, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын түүвэрт хамрагдаж өгсөн 107.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 138,019.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 106,220.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 31,739.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 60.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ТӨБЗГ-ын даргын 2020 оны А-1/889 дугаар "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгийн дагуу Оюуны өмчийн газраас ХЗДХЯ-нд шилжүүлсэн 4,595.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд дансны ангилал зөрүүлж Үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэснийг Үндсэн хөрөнгө худалдсаны гарз болгон залруулсан;
2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайланг 27,635.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 2-т заасан *"Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах зарчим"*-тай нийцээгүй тул аудитын явцад залруулсан;
3. Архивын байрны урсгал засварын тендерийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа Сүлдэт цамхаг констракшн ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан гэрээний ажил дуусгавар болох хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөр заасан байхад ажил гүйлгээг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүйг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй 31,739.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Оюуны өмчийн газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг Сангийн сайд болон, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 дүгээр тушаалаар батлагдсан *"Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам"*-ын дагуу тэг үлдэгдэлтэй данс нээж төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүй, зохих зөвшөөрөлгүйгээр Голомт банкны 1175116159 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т *"Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ"*, 35.4-т *"Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн*

байгууллагад данс нээхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай байх албан шаардлага өгөх.

2. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 0680 дугаар захирамжаар Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Э.Мягмардоржийг тус газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Б/32 дугаар "Ажлаас халах тухай" тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг биелүүлж ажилгүй байсан хугацааны цалин болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал нийт 31,739,385.0 /гучин нэгэн сая долоон зуун гучин есөн мянга гурван зуун наян тав/ төгрөгийн нөхөн олговрыг олгохдоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"*, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т *"Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах тухай байх албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 60.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Оюуны өмчийн газар нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг 30 гаруй төрлийн үйл ажиллагааны үндсэн орлогыг НББ-дээ төрлөөр нь ангилан бүртгэдэггүй бөгөөд аудитаар зөвлөмж өгснийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус газар нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг 30 гаруй төрлийн үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлдээ төрлөөр нь ангилан бүртгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.6-д "*Байгууллага нь дансны нээгдсэн жагсаалт дахь төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлогыг өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамааран орлогын нэр төрлөөр нь ангилан бүртгэх ...*" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Орлогын төрлөөр ангилж бүртгэхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны үндсэн орлогыг нягтлан бодох бүртгэлд төрлөөр нь ангилан бүртгэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Холбогдох журмыг мөрдөж, орлогоо төрлөөр нь ангилна.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Жи-мобайл ХХК-ний мессеж үйлчилгээний дугаарын барьцаа 60.0 мянган төгрөгийг авлагаар тусгалгүй, зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн тооцоог урьдчилан хянан баталгаажуулж, авлага үүсгэж бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Холбогдох гүйлгээг авлагад бүртгэж, цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Оюуны өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021 он			САГ-2021/218/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Оюуны өмчийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Оюуны өмчийн газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг Сангийн сайд болон, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам"-ын дагуу тэг үлдэгдэлтэй данс нээж төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүй, зохих зөвшөөрөлгүйгээр Голомт банкны 1175116159 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Энхсүх Э.Оюун-цэцэг
2	Тус газар нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Шадар сайдын 2006 оны 59 дүгээр тушаалын дагуу төвлөрүүлдэг 30 гаруй төрлийн үйл ажиллагааны үндсэн орлогыг НББ-дээ төрлөөр нь ангилан бүртгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Энхсүх Э.Оюун-цэцэг
3	Жи-мобайл ХХК-ний мессеж үйлчилгээний дугаарын барьцааг авлагаар тусгалгүй, зардалд бүртгэсэн.	60.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Энхсүх Э.Оюун-цэцэг
	Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Э.Мягмардоржийг тус газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн ажлаас халах тухай тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг биелүүлж ажилгүй байсан хугацааны цалин болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал 31.7 сая төгрөгийг нөхөж олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.	31,739.4	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Энхсүх Э.Оюун-цэцэг
ДҮН		31,799.4			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 23

№ 08/A0170051

Улаанбаатар хот

САГ-2021/248/СТ-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Оюуны өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 0680 дугаар захирамжаар Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Э.Мягмардоржийг тус газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Б/32 дугаар “Ажлаас халах тухай” тушаалыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийг биелүүлж ажилгүй байсан хугацааны цалин болон эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал нийт 31,739,385.0 /гучин нэгэн сая долоон зуун гучин есөн мянга гурван зуун наян тав/ төгрөгийн нөхөн олговрыг олгохдоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Albm Shaardlaga 2021-0223audiin 2-R Газар6.Docx


001080984

1. Төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, Нягтлан бодогч Э.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЦЭРЭННАМЖИЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 23

№ 07/A0170051

Улаанбаатар хот

САГ-2021/018/СТА-ПМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Оюуны өмчийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оюуны өмчийн газрын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг Сангийн сайд болон, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам"-ын дагуу тэг үлдэгдэлтэй данс нээж төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүй, зохих зөвшөөрөлгүйгээр Голомт банкны 1175116159 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, Нягтлан бодогч Э.Оюунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2021-0223auditin 2-R Газар7.Docx

001689987

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]